

ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРМИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Дүрмийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

2019 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 56 дугаар зүйлийн 56.2-т “Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батална” гэж заасны дагуу Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийн төслийг боловсруулаад байна.

Төрийн удирдлагын шинэтгэлийг хэрэгжүүлж байгаа улс орнуудад төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөнд тавих олон нийтийн хяналтад ихээхэн ач холбогдол өгч байгаа бөгөөд энэ нь орчин үед төрийн үйлчилгээ нь “бюрократ” төрийн хандлагаас “иргэндээ үйлчлэгч, эдийн засгийг зохицуулагч” төрийн хандлагад шилжиж байгаатай холбоотой юм. Олон улсын туршлагаас үзэхэд олон нийтийн хяналтын дүнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, хэрэглэгчдийн болон төрийн үйлчилгээг үзүүлж буй байгууллагуудын аль алиных нь үйл ажиллагааны зардал буурдаг. Түүнчлэн төрийн удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулах, төрөөс иргэддээ үйлчлэхэд иргэдийн өөрсдийн нь оролцоог нэмэгдүүлэх, төрийн удирдлагын шийдвэр гаргахад тэдний санал, хүсэлтийг харгалзан үзэх нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг байна.

Олон нийтийн хяналтыг чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн зэрэгцээ олон нийтийн нэгдэл, төрийн бус, ашгийн бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлдэг. Олон нийтийн хяналтыг улс орнууд институцчилэхдээ янз бүрээр хандсан байдаг боловч төрийн бүх шатны байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтээс тавих хяналтыг эрх зүйн зохицуулалтад оруулах замаар үр нөлөөг нь дээшлүүлэхэд голлон анхаарч байна.

Хоёр. Олон нийтийн зөвлөлийн дүрмийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Олон нийтийн зөвлөлийн дүрмийн төсөл 9 зүйл 14 хэсэг, 54 заалттай байна.

Нэгдүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэгт Олон нийтийн хяналтын зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрх, байгуулах журам, бүтэц, бүрэлдэхүүн, дарга, гишүүний эрх, үүрэг, Гуравдугаар бүлэгт Олон нийтийн хяналтын арга хэлбэр, үйл ажиллагааны журам, Дөрөвдүгээр бүлэгт Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт, Тавдугаар бүлэгт Мэдээллийн тогтолцоо, Зургадугаар бүлэгт Олон нийтийн хяналтын мөрөөр авах арга хэмжээ, Долдугаар бүлэгт Бусад байгууллагатай хамтрах, харилцах зарчмыг тусгасан.

Гурав. Дүрмийн төсөл батлагдсаны дараа үүсэх үр дагавар, шийдвэрлэх арга хэмжээний санал

Дүрмийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд тавих хяналтыг эрхлэх байгууллага бий болж, энэхүү хяналтад олон нийтийн оролцоо нэмэгдэж, төрийн үйлчилгээтэй холбогдсон журам батлах, төрийн захиргааны

байгууллагаас шийдвэр гаргах үйл ажиллагаанд хэрэглэгчдийн төлөөлөл оролцох оролцоог хангах нэг боломж нээгдэх юм. Эдгээр нь төрийн үйлчилгээг сайжруулах чухал хөшүүрэг болно.

Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Зөвлөл байгуулагдсанаар төрийн удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд дүрмийнхээ хүрээнд хяналт тавих хуулиар олгогдсон боломжийг үгүйсгэхгүй бөгөөд харин тэдгээрээс Зөвлөлтэй харилцаж хамтран ажиллах илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх юм.

Дөрөв. Дүрмийг дагаж мөрдөхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох эрх зүйн актын талаар

Зөвлөлийн дүрмийг дагаж мөрдөхтэй холбогдуулан Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журамд холбогдох тодотгол оруулах шаардлага үүсэж болох боловч журмын зохицуулалтын зарчмыг хөндөхгүй.

Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилттэй холбогдон дүрэмд туссан зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон Засгийн газар зарим эрх зүйн актад зохих нэмэлт оруулах шаардлага гарч болох юм. Хэрэв Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн зарчмыг хууль тогтоомжоор тогтоох ёстой гэж үзвэл Төрийн албаны тухай хуульд зохих нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулан УИХ-д оруулан шийдвэрлүүлэх шаардлага гарч болзошгүй байна.

-oOo-

ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилт нь Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан Олон нийтийн хяналтын зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/-ийн бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагаа, олон нийтийн хяналтын зарчим, журам, хамрах хүрээ, үндсэн арга хэлбэрийг тодорхойлж, эдгээртэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ дүрэмд заасан олон нийтийн хяналтын /цаашид “Хяналт” гэх/ зорилго нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг сайжруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангахад орших ба олон нийтийн хяналт энд дурдсан гурван асуудлын хүрээнд хэрэгжинэ.

1.3. Хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хараат бус, бодитой, улс төрийн нөлөөллөөс ангид, нээлттэй, ил тод байх, олон нийтийн сайн дурын оролцоонд түшиглэх зарчмыг баримтална.

1.4. Энэ дүрэмд заасан зарим нэр томъёог доор дурдсанаар ойлгоно:

1.4.1. “Төрийн үйлчилгээ” гэж Төрийн байгууллага, түүний албан хаагч хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны цогцыг;

1.4.2. “Төрийн үйлчилгээний чанар” гэж гэж төрийн байгууллага, түүний албан хаагч төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд үзүүлэхдээ хууль тогтоомжид заасан шаардлага, стандартыг бүрэн хангасан байхыг;

1.4.3. “Төрийн үйлчилгээний хүртээмж” гэж төрийн байгууллага, түүний албан хаагч төрийн үйлчилгээг шаардлагатай хэрэглэгчдэд болон зорилтот бүлэгт бүрэн хүргэж чадсан байхыг;

1.4.4. “Төрийн үйлчилгээний үр нөлөө” гэж төрийн байгууллага, түүний албан хаагч төрийн үйлчилгээг үзүүлсний үр дүн нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг бүрэн хангасан, энэ талаар тэдний сэтгэл ханамж эерэг байхыг.

1.5. Энэ дүрмийн 1.2-т заасан олон нийтийн хяналтад хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, тэдгээрийн харьяа төрийн захиргааны байгууллага, албан газар, бүх шатны Засаг даргын Тамгын газар, төрийн үйлчилгээ үзүүлж буй бусад байгууллагыг хамруулна.

1.6. Энэ дүрэмд заасны дагуу явуулж буй олон нийтийн хяналтын үйл ажиллагаа нь Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй төрийн бус байгууллагуудаас хууль

тогтоомжийн хүрээнд, өөрийн дүрмийн дагуу төрийн үйлчилгээнд хяналт тавихыг хязгаарлахгүй.

Хоёр. Олон нийтийн хяналтын зөвлөлийг байгуулах журам, түүний бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг

2.1. Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс нэр дэвшүүлсэн иргэдийн дундаас сонгон шалгаруулж, 9 гишүүнтэйгээр, 5 жилийн хугацаагаар Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө.

2.2. Хяналтын зөвлөлийн гишүүн нь төрийн албаны хууль тогтоомжийн талаар зохих мэдлэгтэй, улс төрийн намын гишүүн бус, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэн байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хүйсийн төлөөллийг хангасан байна. Зөвлөлийн гишүүн нь төрийн албан хаагч байж болохгүй.

2.3. Хяналтын зөвлөлийн гишүүн нь олон нийтийн хяналтын үйл ажиллагаанд оролцохдоо нэр дэвшүүлсэн байгууллагынхаа өмнө аливаа үүрэг хүлээхгүй.

2.4. Хяналтын зөвлөлийн даргыг Хяналтын зөвлөлийн гишүүд дотроосоо сонгож, Төрийн албаны зөвлөл батламжилна.

2.5. Аймаг, нийслэлд тухайн нутаг дэвсгэрт энэ дүрэмд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх Олон нийтийн хяналтын салбар зөвлөл /цаашид “Хяналтын салбар зөвлөл” гэх/ ажиллана. Хяналтын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл энэ дүрмийн 2.1-д заасан байгууллагуудын орон нутаг дахь салбараас нэр дэвшүүлсэн иргэдийн дундаас сонгон шалгаруулж, 7-9 гишүүнтэйгээр 5 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Хяналтын салбар зөвлөлийн даргыг Хяналтын салбар зөвлөлийн гишүүд дотроосоо сонгож, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл батламжилна.

2.6. Энэ дүрмийн 2.1, 2.5-д заасан олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хүндэтгэх шалтгаангүйгээр олон нийтийн хяналтын үйл ажиллагаанд 3 сараас дээш хугацаанд оролцоогүй, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхдээ ёс зүйн ноцтой зөрчил гаргасан бол түүнийг олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүнээс огцруулна. Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүн төрийн албанд томилогдсон, улс төрийн намын гишүүн болсон, түүнчлэн эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгаанаар чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн бол түүнийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлж, энэ журмын дагуу нөхөн томилно.

2.7. Хяналтын зөвлөл болон аймаг, нийслэлийн Хяналтын салбар зөвлөлүүд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.7.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд тавих хяналтыг энэ журамд заасны дагуу зохион байгуулах, түүнд олон нийт, хэрэглэгчдийн оролцоог хангах;

2.7.2. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.8-д заасан хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулах;

2.7.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөний талаарх олон нийтийн сэтгэл ханамжийн төлөв байдал, санал үнэлэмжийг судлан дүгнэж, судалгааны тайлан, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг сайжруулах санал, зөвлөмжийг холбогдох байгууллага болон Засгийн газарт хүргүүлж, Төрийн албаны зөвлөлд танилцуулах.

2.8. Хяналтын зөвлөл болон аймаг, нийслэлийн Хяналтын салбар зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд зөвлөмж гаргах бөгөөд тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав. Олон нийтийн хяналтын зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг

3.1. Энэ дүрмийн 2.1, 2.5-д заасан олон нийтийн хяналтын зөвлөлийн дарга, гишүүн дараах эрх, үүрэгтэй:

3.1.1. Зөвлөлийн дарга зөвлөлийг төлөөлж бусад байгууллагатай харилцах, гэрээ, хэлцэл байгуулах, зөвлөлийн ажлыг удирдан зохион байгуулж, зөвлөлийн хуралдааныг товлох, удирдан явуулах, зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг хуваарилж, зарцуулах, тайлагнах, гишүүдийн ажил үүргийн хуваарийг зөвлөлийн хуралдаанаар батлуулах үүрэг хүлээж, гишүүдэд хяналтын үүргээ зохих ёсоор гүйцэтгэх талаар шаардлага тавих, үүрэг даалгавар өгөх эрхтэй.

3.1.2. Зөвлөлийн гишүүн нь зөвлөлийн үйл ажиллагаа болон хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, санал гаргах, хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбогдох мэдээ, материалтай танилцах, хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг хариуцан зохион байгуулах, холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу шаардан танилцах эрх эдэлж, зөвлөлийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, улс төрийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, төрийн байгууллага, албан хаагчид, иргэдтэй харилцахдаа ёс зүй, харилцааны соёлыг эрхэмлэх, хэрэглэгчдийн хүсэлт, шаардлагад хүндэтгэлтэй хандах үүрэг хүлээнэ.

Дөрөв. Олон нийтийн хяналтын арга хэлбэр

4.1. Төрийн үйлчилгээнд тавих олон нийтийн хяналтыг дараах арга хэлбэрээр хэрэгжүүлнэ:

4.1.1. Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох баримт бичиг, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулах, танилцах, судалгаа хийх; Төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага, албан тушаалтан нь шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.

4.1.2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах,

4.1.3. Төрийн үйлчилгээний үйл явцыг танилцах.

4.2. Хэрэглэгчдийн үнэлгээг дараах арга, хэлбэрээр зохион байгуулна:

4.2.1. Шаардлагатай бол хөндлөнгийн судлаач, шинжээчийг тохиролцсоны үндсэн дээр үнэлгээнд оролцуулна.

4.2.2. Иргэдийг тэдгээрийн сайн дурын үндсэн дээр сонгон, хэрэглэгчийн өөрийн үнэлгээ хийлгэх замаар олон нийтийн оролцоог хангана.

4.2.3. Үнэлгээний ажлын удирдамж, үнэлгээнд оролцох хэрэглэгчийн эрх, үүргийг урьдчилан танилцуулсан байна. Үнэлгээний ажилд хэрэглэгчийг албадан оролцуулах, өөрийн хүсэлтээр оролцоход нь саад учруулахыг хориглоно.

4.3. Хяналтын зөвлөл болон Хяналтын салбар зөвлөлүүд /цаашид “олон нийтийн хяналтын зөвлөлүүд” гэх/ нь хяналт тавих үйл ажиллагааныхаа явцад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль ёсны бүрэн эрхэд хөндлөнгөөс хутгалдан оролцохгүй, хэвийн үйл ажиллагаанд нь саад хийхгүй байх үүрэг хүлээнэ.

4.4. Олон нийтийн хяналтын зөвлөлүүд иргэдийн гомдол, мэдээлэлд судалгаа, дүгнэлт хийсний үндсэн дээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх салбар чиглэлийг тодорхойлох бөгөөд тодорхой иргэний өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг хүлээхгүй.

Тав. Олон нийтийн хяналтын зөвлөлүүдийн үйл ажиллагааны журам

5.1. Олон нийтийн хяналтын зөвлөлүүдийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь тэдгээрийн хуралдаан мөн.

5.2. Олон нийтийн хяналтын зөвлөлийн хуралдаанд гишүүдийн дийлэнх олонх хүрэлцэн ирснээр хүчинтэй болж, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

5.3. Хуралдааны дэгийг зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар батална.

5.4. Хуралдаанаас гаргасан зөвлөмжид зөвлөлийн дарга /түүний эзгүйд хуралдаан даргалагч/ гарын үсэг зурж баталгаажуулна.

5.5. Хяналтын зөвлөл нь аймаг, нийслэлийн Хяналтын салбар зөвлөлийн үйл ажиллагааг нэгтгэн удирдаж, олон нийтийн хяналтын ажлын удирдамж, чиглэл өгч, арга зүйн зөвлөгөөгөөр хангана. Төрийн албаны зөвлөл нь Хяналтын зөвлөлд түүний чиг үүргийн дагуу тодорхой асуудлаар чиглэл өгч, хяналт, үнэлгээ хийлгэж болно.

5.6. Хяналтын салбар зөвлөл өөрийн үйл ажиллагааны тайланг Хяналтын зөвлөлд тогтоосон хугацаанд хүргүүлж байна.

Зургаа. Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

6.1. Олон нийтийн хяналтын зөвлөлүүдийн үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6.2. Хяналтын зөвлөл нь тухайн жилд хийх хяналтын ажлын төлөвлөгөө, энэ журмын 2.7.2-т дурдсан хэрэглэгчийн үнэлгээний ажлын хуваарийг баталж, түүнд шаардагдах хөрөнгийн зардлын тооцоог хавсарган Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газар тухайн жилд шаардагдах хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын жил бүрийн төсөвт тусган баталж, гэрээ байгуулсны үндсэн дээр санхүүжүүлнэ.

6.3. Хяналтын салбар зөвлөл энэ журмын хяналтын ажлын төлөвлөгөө, зардлын тооцоог аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга гэрээ байгуулсны үндсэн дээр хяналтын ажлын зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусгуулж санхүүжүүлнэ.

6.4. Олон нийтийн хяналтын зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжихэд зориулагдсан олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн бус байгууллага, иргэдийн хандивыг хяналтын зорилгоор ашиглах бол энэ талаар Хяналтын зөвлөл нь Засгийн газарт, Хяналтын салбар зөвлөл нь аймаг, нийслэлийн Засаг даргад урьдчилан танилцуулна.

6.5. Олон нийтийн хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Төрийн албаны зөвлөлтэй зөвшилцөн Засгийн газар тогтооно.

Долоо. Мэдээллийн тогтолцоо

7.1. Олон нийтийн хяналтын зөвлөлүүд нь чиг үүргийнхээ хүрээнд төрийн албаны нэгдсэн мэдээллийн сангаас төрийн албан хаагчийн хувийн мэдээллээс бусад мэдээлэлтэй танилцаж болно.

7.2. Хяналтын зөвлөл нь өөрийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг Төрийн албаны зөвлөлд, Хяналтын салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тус тус тогтмол хүргэж хамтран ажиллах бөгөөд Хяналтын зөвлөл жилийн нэгдсэн тайлангаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлд тус тус тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

7.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөний талаарх хяналт шалгалтын дүн, судалгаа, үнэлгээний тайланг Төрийн албаны зөвлөлд танилцуулсан тухай мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Найм. Олон нийтийн хяналтын мөрөөр авах арга хэмжээ

8.1. Олон нийтийн хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, холбогдох албан хаагчид хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх, тавьсан санал, зөвлөмжийг судалж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авч, хариу мэдэгдэх үүргийг холбогдох бүх шатны байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

8.2. Олон нийтийн хяналтын зөвлөлүүдээс өгсөн санал, зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээг орхигдуулсан, зөрчил, дутагдлыг арилгаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор зохих дээд шатны байгууллагад болон Төрийн албаны зөвлөлд мэдэгдэнэ.

Ес. Бусад байгууллагатай хамтран ажиллах

9.1. Энэ дүрэмд заасан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөөгөө уялдуулсны үндсэн дээр төрийн хяналт шалгалтын холбогдох байгууллагатай хамтран ажиллаж болно.

9.2. Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнд үндэслэн тус тусын чиг үүргийнхээ хүрээнд шийдвэр гаргаж, шийдвэрийнхээ үндэслэлийг хариуцах зарчим баримтална.

9.3. Олон нийтийн хяналтын зөвлөлүүд чиг үүргийнхээ хүрээнд хамаарахгүй асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

-оОо-